

**XIX ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН ГОО ЗҮЙН
СЭТГЭЛГЭЭНИЙ АСУУДАЛ**

Б.Дэлгэрмаа *

Дэлхийн аль ч үндэстэн ард түмэн өөрийн гэсэн гоо сайхны үнэлгээтэй, мэдлэгтэй байдаг. Энэ зүй ёсны хуулийн дагуу монголчууд ч гэсэн хүрээлэн байгаа орчноо гоо сайхны хувьд үнэлсэн олон зуун жилийн мэдлэгтэй ард түмэн юм. Монголчуудын гоо сайхны мэдлэг, юуны өмнө амьдарч буй орчин, эрхэлж буй аж ахуй, аж төрөх ёс, зан заншил, уламжлалт соёл иргэншилтэй нь холбоотой. Энэ бүхнийхээ онцлогоор монголчуудын амьдрахуйн үндсэн онцлог бусад ард түмнийхээс ялгарч гардаг. Монголчуудын гоо сайхны үзэл бодол амьдрахуйн нөхцөл байдалтай нь шууд холбоотой юм. Монголчуудын гоо сайхны мэдлэг нүүдлийн амьдралын өвөрмөц онцлог дунд боловсруулагдсан. Монголчууд, байгаль орчин, нийгмийн ахуйн олон талтай харилцаж, түүнийгээ гоо сайхны талаас болон уран сайхны талаас нэгтгэн дүгнэж, өөрсдийн гоо сайхны мэдлэгээ хуримтлуулж ирсэн. Бид монголчуудын гоо сайхны мэдлэгийг судлахдаа монголчуудын философи сэтгэлгээний мэдлэг, ёс суртахуун, зан заншлын мэдлэг, шашин шүтлэгийн байдал, уламжлалт эрхлэх аж ахуй зэрэг мэдлэгийн олон салбарыг судлах явдалтай хослуулж хийх ёстой.

XIX зууны үеийн манай эрдэмтэд, сэтгэгчид өөрсдийн зохиол бүтээлүүдэд гоо зүйн асуудлыг боловсруулсан нь цөөнгүй байдаг. Гоо зүйн шинжлэх ухааны гол ойлголт бол сайхны тухай асуудал байдаг. Монголчууд сайхны тухай асуудлыг Өрнө дахиных шиг категорийн хэмжээнд онолын төвшинд боловсруулж байгаагүй боловч сайхны тухай асуудлыг зарчмын хувьд зөв ойлгож байсан юм. Монголын сэтгэгчдийн зохиол бүтээлүүдэд сайхны тухай асуудал онолын шинжтэй байдлаар илэрч гарч байсан. Тухайлбал, Цахар гэвш Лувсанчүлтэм, Говийн ноён хутагт Данзанравжаа, эрдэмтэн зохиолч Инжиннаш нарыг энд онцлон авч үзэх хэрэгтэй юм. Тухайлбал, Цахар гэвш Лувсанчүлтэм (1740-1810 он) “Галын шашдир” зохиолдоо:

Үнэхээр идээ будаа хийж үл болох савыг

Үзэмжтэй сайхан боловч савд тооцох хэрэггүй,

Үнэхээр эрдэм ном үл сурах тойдыг

Үзэмжтэй сайхан боловч тойнд тооцох хэрэггүй гэжээ.

Лувсанчүлтэм сайхныг гадаад өнгө үзэмжийн асуудал болгож үзээгүй байна. Уг зүйлийн дотоод чанартай нь, хэрэгцээ хангах чанартай нь холбож ойлгож байжээ.

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Өөрөөр хэлбэл, сайхан бол тухайн зүйлийн гадаад, дотоод хоёр талын зөв хослол, нэгдэл гэж ойлгосон нь харагдаж байна.

Говийн ноён хутагт Данзанравжаа (1803-1856 он) гоо сайхны асуудлыг “*Үлэмжийн чанар*”, “*Саруул тал*” зэрэг дуунууддаа гаргасан байна. Тухайлбал, “*Саруул тал*” дуундаа:

Саруул тал байвч

Шавартай газрыг нь мэдээрэй,

Сайхан амраг байвч

Санаа сэтгэлийг нь таниарай гэж бичжээ.

Данзанравжаа сайхны тухай асуудлыг зөвхөн гадаад өнгө үзэмжийн асуудал биш, гадаад дотоод хоёр талын нэгдэл юм гэж үзсэн байна. Энэ нь манай ардын уламжлалт мэдлэгтэй холбоотой. Монголчууд “*Хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа*”, “*Хүний сайныг ханилан байж мэд, хүлгийн сайныг унан байж мэд*” гэж ярьдаг бөгөөд эдгээр ардын зүйр цэцэн үгэнд сайхан болон сайн гэдэг бол шууд танигддаггүй, удаан хугацааны дараа танигддаг гэсэн санаа байгаа юм. Монголчууд сайн сайхан гэсэн ойлголтуудыг нягт холбон авч үздэг билээ. Данзанравжаа өөрийн уран бүтээлдээ хүмүүний гоо сайхан ба, хүний үйл амьдрал, нийгмийн амьдралын сайхан, муухайн олон талт байдлыг илтгэн харуулсан байдаг.

Сайхны асуудлыг нэлээд онолын шинжтэй гаргаж ирсэн сэтгэгч бол Монголын эрдэмтэн зохиолч Ванчинбалын Инжиннаш (1837-1893 он) юм. Тэрээр “*Хөх судар*” романыг бичсэн бөгөөд уг романы “*Товчит тольт*” хэмээх тэргүүн бүлэгт нь Инжиннашийн философи, гоо зүйн үзэл баримтлалууд илэрч гарсан байдаг юм. Энэ зохиолдоо Иншиннаш сайхны тухай асуудлыг ийнхүү авч үзжээ. “*Үлгэрлэвээс, ертөнцийн сайхан уур амьсгалаас туйлын сайхан өнгөт нь цэцэг атал, цэцэг бүр адилгүй өөр өөртөө нэгэн зүйлийн сайхан өнгө буй*” гэсэн байна. Нэгэн зүйлийн сайхныг нөгөө зүйлийн сайхантай адилтгаж болохгүй, өөр өөртөө сайхан байна, сайхан бол харьцангуй юм гэсэн санааг Инжиннаш боловсруулжээ. Мөн сайхныг хүн өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаараа буй болгож болно гэж үзжээ. Жишээлбэл:

Өөрийн тарьсан амунаас амттай нь үгүй,

Өөрийн нэхсэн бүснээс дулаан нь үгүй¹ гэжээ.

Энд хүн сайхныг зөвхөн танин мэддэг төдий биш, сайхныг хүн өөрийн үйл ажиллагаагаар, хөдөлмөрөөр бүтээдэг юм гэсэн санааг гаргасан байна. Мөн Инжиннаш урлагийн мөн чанар, урлан бүтээх үйл ажиллагааны зарчмыг зөв ойлгож боловсруулж байжээ. Энэ талаар “*Хүний сэтгэлийг хөдөлгөж чадахгүй юм бол хөндлөн бийрийг хөшихийн хэрэг юун*” гэж өгүүлжээ.

XIX зууны сүүлч үе, XX зууны эхэн үед Монголын урлагт шүүмжлэлт хандлага, иргэншлийн хандлага бий болсон юм. Манай сэтгэгчид өөрсдийн зохиол бүтээлүүддээ гоо зүйн нэг гол ойлголт болох инээдэмтэйн тухай үзэл санааг боловсруулж байсан. Тухайлбал, Данзанравжаа “*Ичиг, ичиг*” шүлэгтээ:

Номоо мэддэггүй лам нар ичиг ичиг,

Төрөө мэддэггүй ноёд ичиг ичиг,

Айлаа мэддэггүй хүүхнүүд ичиг ичиг гэжээ. Мөн Данзанравжаа цааш нь ийнхүү өгүүлжээ. Үүнд:

Аяа бас буян хураасангүй насажсан хөгшид ичиг ичиг,

¹ Ж.Төмөрбаатар (2010) *Монголын гоо сайхны сэтгэлгээний түүхэн тойм*. 49 х., Улаанбаатар.

*Аяа, бас сэтгэлээ зассангүй гангалагч залуучууд ичиг ичиг,
Аяа, бас аавыгаа өргөхгүй эрийг өргөгч охид ичиг ичиг,
Аяа, бас өөрийн гэмийг үзэхгүй бусдын гэмийг гаргагч хэрсүүчүүд ичиг ичиг,
Аяа, бас өөрөө айл хэсэж ирээд эхнэрээ шаргаагч эрчүүд ичиг ичиг,
Аяа, бас эрчүүдийн үгэнд орохгүй бусадтай ханилагч эхнэрүүд ичиг ичиг,
Аяа, бас энэ гэмүүд надад буй бол олны дундаас би ганцаар ичиг ичиг,
Аяа, бас хэрэв бусад их багад буй бол хэн ч бол тэр ичиг ичиг² гэжээ.*

Энэ бүхнээс харахад, Данзанравжаа олз хүндлэл, хувийн ашиг хонжоо, нэр алдрын төлөө бол юунаас ч буцахгүй атлаа, эрдэм номын төлөө, бусдад хэрэг тустай нийтийн сайн үйлийн төлөө явдаггүй, үнэнч шударга биш, ажил, амьдралын утга учрыг өнөө маргаашийн идэх хоол, өмсөх хувцас, эд баялаг төдийгөөр хязгаарлагч, нийгмийн ёс горимыг үл тоомсорлогч нарыг шүүмжилжээ. Мөн энд гоо сайхны асуудалд зөвхөн гадаад өнгө үзэмж чухал биш, сэтгэлийн сайхан болохыг чухалчилжээ.

Тухайн үеийн нийгмийн доройтол, үйл ажиллагааны гаж буруу байдлыг үл тэсвэрлэж, хурцаар шүүмжлэх байдал урлаг, уран зохиолд тод илэрч байв. Манай сэтгэгчид лам, ноёдоос айж эмээлгүй тэр үеийн нийгмийн байдлыг ил тод шүүмжилж байв. Энэ үеийн монголын урлаг, уран зохиолд шүүжлэлт реализмын шинж голлож байсан юм.

XIX зууны үеэс монголын урлаг иргэншлийн хандлага руу орсон юм. Бурхан, тэнгэр, шашны үзэл санаа гэхээсээ илүү хүний амьдрал, үйл ажиллагааг урлагт тусгах болсон байна. Хүний жинхэнэ бодит амьдрал, хайр сэтгэл янаг амрагийн тухай сэдэвтэй бүтээлүүд гарах болов. Жишээ нь, зураач Цагаан Жамбын “Алтайн амьтан”, “Жаргалын найман морь”, “Тэмээн сүрэг” зэрэг бүтээлүүд бол жинхэнэ бодит монгол ахуйг тусгасан бүтээлүүд юм.

Энэ өгүүлэлдээ XIX зууны үеийн монголын сэтгэгчдийн гоо зүйн үзлийн гол агуулгыг гаргахыг зорилоо. Монголын сэтгэгчид гоо зүйн гол ойлголт болох сайхны асуудлыг боловсруулахдаа тухайн зүйлийн гадаад, дотоод хоёр талын нэгдлээр авч үзэж байжээ. XIX зууны үеийн урлагт шүүмжлэлт болон иргэншлийн хандлага илэрч гарч байсан байна.

² Г.Лхагвасүрэн (2003) *Ноён хутагт Данзанравжаа*. 177 х., Улаанбаатар

SUMMARY

In this article, the author tries to investigate the aesthetic thinking of the Mongolian philosophers in the XIX century. Beauty is studied as the main part of aesthetics-it is considered to be a combination of inner beauty and outer beauty by Mongolian philosophers. Criticized and civilized tendencies appeared in art of the XIX century.

НОМ ЗҮЙ

- Гомбосүрэн Ц.(2008) *Философи*.(ред. М.Отгонбаяр).Улаанбаатар.
Жүгдэр Ч.(2006) *Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил* (ред. Г.Лувсанцэрэн). Улаанбаатар.
Лхагвасүрэн Г. (2003) *Ноён хутагт Данзанравжсаа*. Улаанбаатар.
Монголын соёлын түүх. (1999) *II боть*. Улаанбаатар.
Монголын философийн түүх. (2001) *III, IV дэвтэр*. (ред. Г.Лхагвасүрэн, Д.Дашжамц). Улаанбаатар.
Д.Наранцацрал. (2009) *Гоо зүй* (ред. Б.Дэлгэрмаа). Улаанбаатар.
Р.Рэгзэндорж. (2003) *Гоо зүйн лекцүүд*. Улаанбаатар.
Б.Сумьяа. (1998) *Монголын нүүдэлчдийн соёл: оршихуй, эс оршихуй*. Улаанбаатар.
Ж.Төмөрбаатар. (2010) *Монголын гоо сайхны сэтгэлгээний түүхэн тойм* (ред. Б.Дэлгэрмаа). Улаанбаатар.